



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/222

Сүхбаатар сум

### Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.3, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн А/02 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны “Авто замын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын 30 дугаар зүйлийн 30.1-д “...орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах замын чиглэл, замын урт, төлбөрийн хэмжээг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус тогтооно” гэж заасан тул аймгийн Засаг даргын 2005 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 101 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

2.Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах замын чиглэл, замын урт, төлбөрийн хэмжээг болон төлбөр авах журмыг боловсруулан батлуулахыг Сэлэнгэ аймаг дахь авто тээврийн газрын дарга /Ж.Батцогт/-д даалгасугай.

3.Захирамжийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтэс хүргүүлж, бүртгүүлэхийг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 07 өдөр

Дугаар A/223

Сүхбаатар сум


### Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, Цагдаагийн байгууллагын тухай, Албадан хөдөлмөр эрхлэх тухай хуулиуд тус тус хүчингүй болсонтой холбогдуулан аймгийн Засаг даргын 2003 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 104 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

2.Захирамжийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтэс хүргүүлж, бүртгүүлэхийг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ